



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шивээговь сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн хураангуй тайлан

Аудитын код: ГСА-2024/03/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Говьсүмбэр
аймаг

2024 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 70543179, Цахим хаяг:
sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр

Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn

Аудитор: С.Батцэцэг

Цахим хаяг: battsetsegsa@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviumber@audit.gov.mn

2024.08.25 № 52

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шивээговь сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын өс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тус байгууллага нь бүх үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

008020133

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. ТЭЗ-тай байгуулсан жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 108 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 87.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		478,029.8	1,125,656.8
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	304,826.9	728,698.2
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	127,460.0	218,850.1
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	29,942.9	44,634.0
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	15,800.0	27,099.5
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	10	0.0	106,375.1
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		1,095,576.5	1,235,860.4
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	1,095,576.5	1,235,860.4
39200	Биет хөрөнгө		1,080,217.7	1,220,851.6
39300	Биет бус хөрөнгө	13	15,358.8	15,008.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,573,606.3	2,361,517.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		11,179.0	36,976.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	11,179.0	36,976.9
41300	Өглөг	17а, 17б	11,179.0	36,976.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,562,427.3	2,324,540.4
51	Засгийн газрын хувь оролцоо		1,562,427.3	2,324,540.4
51100	Засгийн газрын оруулсан капитал		643,941.3	643,941.3
51200	Хуримтлагдсан үр дүн		151,027.2	913,140.3
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		767,458.8	767,458.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,573,606.3	2,361,517.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		3,053,399.4	3,467,309.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО		1,420,302.1	1,933,301.0
110	Орлогын албан татвар		1,190,036.8	1,621,793.5
1100	Хувь хүний орлогын албан татвар		1,190,036.8	1,670,410.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	-48,617.2
113	Хөрөнгийн албан татвар		187,615.6	239,021.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж		42,649.6	72,486.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	218,921.2	353,201.4
120	Нийтлэг татварын бус орлого		218,921.2	353,201.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,414,176.2	1,180,806.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	3,247,102.0	2,622,410.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ		3,247,102.0	2,622,410.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,745,925.9	2,029,294.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		307,772.9	523,294.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		37,099.0	64,260.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		113,983.5	103,117.2
2104	Хангамж, бараа материалын зардал		689,904.6	355,463.2
2105	Нормативт зардал		0.0	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		172,731.3	20,697.6
2107	Томилолт, зочны зардал		7,382.0	11,904.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		17,390.6	460,089.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		399,661.9	490,467.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,501,176.1	593,116.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		-193,702.6	844,898.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		2,802,769.6	460.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		-2,996,472.2	844,438.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,774,491.9	0.0	4,774,491.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-215,223.2	0.0	-215,223.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,559,268.8	0.0	4,559,268.8
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-369.2	0.0	-369.2
9	Тайлант үеийн үр дүн	-2,996,472.2	0.0	-2,996,472.2
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,562,427.3	0.0	1,562,427.3
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,562,427.3	0.0	1,562,427.3
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-82,325.4	0.0	-82,325.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,480,101.9	0.0	1,480,101.9
19	Тайлант үеийн үр дүн	844,438.5	0.0	844,438.5
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,324,540.4	0.0	2,324,540.4

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		3,402,839.8	3,158,774.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО		1,420,302.1	1,933,301.0
110	Орлогын албан татвар		1,190,036.8	1,621,793.5
1100	Хувь хүний орлогын албан татвар		1,190,036.8	1,670,410.8
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		0.0	-48,617.2
113	Хөрөнгийн албан татвар		187,615.6	239,021.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж		42,649.6	72,486.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж		24,883.1	47,587.5
1181	Газрын төлбөр		17,766.6	24,899.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		56,009.9	47,167.3
120	Нийтлэг татварын бус орлого		56,009.9	47,167.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,926,527.8	1,178,306.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,732,441.7	1,974,317.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ		2,732,441.7	1,974,317.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,094,691.0	1,345,130.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		371,463.1	520,819.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		35,856.3	65,319.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		459,451.5	103,117.2
2104	Хангамж, бараа материалын зардал		22,418.0	26,360.9
2105	Нормативт зардал		206.1	299.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		46,563.4	34,790.6
2107	Томилолт, зочны зардал		7,240.0	12,046.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		82,253.5	521,042.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		69,239.1	61,335.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,637,750.7	629,186.5
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		670,398.2	1,184,457.7

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		524,318.4	644,905.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		524,318.4	644,905.6
2200	Дотоод эх үүсвэрээр		524,318.4	644,905.6
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		-524,318.4	-644,905.6
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-550.0	-115,680.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		550.0	115,680.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		145,529.8	423,871.3
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		159,297.1	304,826.9
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		304,826.9	728,698.2

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,974,252.40	2,175,703.36
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,710,629.10	1,432,021.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,489,984.10	1,343,421.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	556,781.40	520,819.01
210101	Үндсэн цалин	303,716.10	292,750.42
210102	Нэмэгдэл	186,290.90	127,062.18
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,574.40	33,149.06
210104	Урамшуулал	19,200.00	43,726.71
210105	Гэрээт ажлын хөлс	16,000.00	24,130.66
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,245.20	65,319.20
210201	Тэтгэврийн даатгал	48,830.60	46,137.51
210202	Тэтгэмжийн даатгал	5,603.60	7,709.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,482.90	3,133.38
210204	Ажилгүйдлийн даатгал	1,120.70	752.71
210205	Эрүүл мэндийн даатгал	11,207.40	7,585.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	524,170.20	472,813.18
210301	Гэрэл, цахилгаан	67,630.20	48,919.61
210302	Түлш, халаалт	387,420.00	383,840.32
210303	Цэвэр, бохир ус	69,120.00	40,053.26
2104	Хангамж, бараа материалын зардал	26,147.00	26,060.92
210401	Бичиг хэрэг	3,900.00	4,687.90
210402	Тээвэр, шатахуун	16,000.00	15,998.20
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,400.00	3,371.35
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480.00	220.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,367.00	1,783.47
2105	Нормативт зардал	533.00	299.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	533.00	299.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	73,760.00	72,271.49
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,800.00	13,592.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,100.00	124.00
210604	Урсгал засвар	58,860.00	58,555.49
2107	Томилолт, зочны зардал	12,261.00	12,046.00
210702	Дотоод албан томилолт	12,261.00	12,046.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	133,234.30	124,251.59
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	128,731.00	121,735.09

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90.30	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,560.00	1,560.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,083.00	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	200.00	77.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,470.00	879.50
210807	Газрын төлбөр	100.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,852.00	49,540.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	91,652.00	49,412.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200.00	128.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	220,645.00	88,600.26
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	207,500.00	76,606.93
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	207,500.00	76,606.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,145.00	11,993.33
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,145.00	11,993.33
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,123,180.70	628,000.77
223001	Бусад хөрөнгө	1,123,180.70	628,000.77
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	140,442.60	115,680.80
230001	Эргэж төлөгдөх зээл	140,442.60	115,680.80
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,974,252.40	2,599,301.49
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,186,323.60	1,163,348.60
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	1,186,323.60	1,163,348.60
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,582,483.20	1,402,762.90
320001	Орон нутгийн төсвөөс	1,582,483.20	1,402,762.90
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	205,445.60	33,189.99
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	33,732.40	30,891.44
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	749.80	2,298.56
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	170,963.40	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	170,963.49
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	594,561.63
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	50.00	50.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00
610001	Төсвийн байгууллага	2.00	2.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	24.00
620001	Удирдах ажилтан	7.00	7.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00
620003	Үйлчлэх ажилтан	2.00	2.00
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,458.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,458.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,114.00
2104	Хангамж, бараа материалын зардал	300.00
210401	Бичиг хэрэг	300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	114.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	114.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,344.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,344.00
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,344.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17,458.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17,458.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	17,458.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 94.2 сая төгрөгийн 8 алдаа¹ илэрснийг завсрын аудитаар 86.2 сая төгрөгийн 7 алдааг, аудитын явцад 8.0 сая төгрөгийн 1 алдааг тус тус залруулсан бөгөөд энэ нь Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэдэг харьяа байгууллагуудын алдаа байна.

Аудитаар нийт 1,330.7 сая төгрөгийн 15 зөрчил² илэрснээс, 11.2 сая төгрөгийн 5 зөрчилд төлбөрийн акт, 1,315.7 сая төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага, 3.8 сая төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнээс 12.2 сая төгрөгийн зөрчил нь харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн байна.

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 1,318.5 сая төгрөгийн 4 зөрчил илрүүлснээс 8.2 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 1,310.3 сая төгрөгийн 3 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүллээ.

Харьяа байгууллагууд

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн, нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүврээр хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан харьяа 1 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 106.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 92.4 сая төгрөгийн 8 алдааг аудитын явцад залруулж, 3.0 сая төгрөгийн 4 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5.4 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 1.3 сая төгрөгийн 3 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Шилэн дансны тухай хууль, бусад хууль тогтоомжийн нийцлийн аудитаар 2.5 сая төгрөгийн 2 зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлсэн байна. /Хавсралт 1-ээс үзнэ үү/

Өмнөх онтой харьцуулахад харьяа байгууллагуудын нийт зөрчлийн дүн 21% буюу 232.5 сая, төлбөрийн акт 49% буюу 6.7 сая, албан шаардлага 2 дахь буюу 899.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн, харин зөвлөмж 673.4 сая төгрөгөөр буюу 5 дахин буурсан байна.

Аудитаар өгсөн албан шаардлагын 0.4% буюу 5.4 сая төгрөг нь санхүүгийн зөрчил, 99.6% буюу 1,310.3 сая төгрөг нь Шилэн дансны хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил байна. /Хавсралт 1, 2-оос үзнэ үү/

3.1 Төлбөрийн акт

3.1.1 2015 болон 2019 онуудад хийгдсэн ажлын барьцаа болох 8.2 сая төгрөгийг чөлөөлөөгүй, гэрээний хугацаа дууссан, гэрээг дүгнээгүй, дансны үлдэгдлийг эдийн засгийн эргэлтэд оруулаагүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, 15 дугаар зүйлийн 15.4.1, 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь заалтыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: 2023 оны барьцаа дансны эхний үлдэгдлийг орон нутгийн орлогод төвлөрүүлэх

3.2 Албан шаардлага

3.2.1 Татварын орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, хуулиар тогтоосон орлогын биелэлтэд хяналт тавьж ажиллаагүйгээс 278.0 сая төгрөгийн зөрчил илэрч байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8.1, 23.8.2, 23.8.12, 23.8.14, 23.8.16, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.2.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Сумын татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь бүрэн биелүүлэх

3.2.2 АИТХ-ын тогтоолоор сумын төсвөөс аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг 747.7 сая төгрөгөөр баталснаас 393.0 сая төгрөгийн төвлөрүүлж, төвлөрүүлэх орлого 354.8 сая төгрөгөөр тасарсан. Өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 15 дугаар зүйлийн 15.4.1 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.9, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтыг тус тус зөрчсөн.

Шийдвэрлэсэн нь: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шивээговь сумын Засаг дарга												
Шивээговь сумын ИТХ	1	0.06			1	0.06	1	0.06				
Шивээговь сумын ЗДТГ	6	86.2	3	53.3	3	32.8	6	86.2				
Шивээговь сумын ОНХС	1	8.0	1	8.0			1	8.0				
Шивээговь сумын ХХС												
Дүн	8	94.2	4	61.3	4	32.86	8	94.2				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шивээговь сумын Засаг дарга	1	8.2	1	8.2								
Шивээговь сумын ИТХ	3	1.7	2	1.2	1	0.5						
Шивээговь сумын ЗДТГ	5	6.7	2	1.8	1	4.9	2	-				
Шивээговь сумын ОНХС		-										
Шивээговь сумын ХХС	1	1.3					1	1.3				
Нийт	10	17.9	5	11.2	2	5.4	3	1.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шивээговь сумын Засаг дарга	1	677.5			1	677.5		

Шивээговь сумын ИТХ								
Шивээговь сумын ЗДТГ								
Шивээговь сумын ОНХС								
Шивээговь сумын ХХС								
Дүн	1	677.5			1	677.5		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шивээговь сумын Засаг дарга	2	632.8			2	632.8		
Шивээговь сумын ИТХ								
Шивээговь сумын ЗДТГ	1	2.5					1	2.5
Шивээговь сумын ОНХС	1	-					1	-
Шивээговь сумын ХХС								
Дүн	4	635.3			2	632.8	2	2.5
Нийт дүн	5	1,312.8			3	1,310.3	2	2.5

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	2	1	1		1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС	2		2					
4	ТТЗ	1	1			1			
5	ТЕЗ								
	НИЙТ	5	2	3		2			

